


НУУРУУДЫН ГАРАЛ ҮҮСЭЛ

ТАНИН МЭДЭХҮЙН МЭДЭЭЛЭЛ

Т.ДАВААГАТАН MSc, Т.РЭНЧИНМЯДАГ Ph.D (ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН, ФИЗИК ГАЗАРЗҮЙ, ОРЧИН СУДЛАЛЫН САЛБАР)

Нуур гэж юу вэ?


Нуур бол хонхор газарт хуримтлагдан тогтсон далай, тэнгистэй холбоогүй, өвөрмөц экологийн орчинг бүрдүүлэгч бие даасан усны нэг төрөл юм (Батчулуун, 2003). Нуур нь өөрийн ай савын хүрээн дэх бусад ландшафтаас туугдан ирэх байгалийн бүхий л элементүүдийг өөртөө хураагч, хуримтлуулагч, хадгалагч болдгоороо онцлог юм. Лимнологи гэх нуур судлалын ухаан нь гидрологийн шинжлэх ухааны салбар болдог бөгөөд нуурын судалгаа нь нуурын өөрийн хэв шинж, түүнийг бүрдүүлэгч байгалийн элементүүдийн шинж төрхийг судалдаг чухал судалгааны салбар юм. Манай оронд 3500 гаруй нуур байдаг ба талбай нь нийт нутгийн 1% орчим болно. Эдгээрийн 85% 1 км² хүртэл, 0.2% нь 1000 км²-аас дээш талбайтай (Батчулуун, 2003).



Нуурын хонхор нь газрын гадаргын рельефийн нэг элемент учир дэлхийн дотоод болон гадаад хүчний харилцан үйлчлэлээр үүсэн бүрэлддэг. Нуурын хэлбэр, хэмжээ, гүн, усны горим нь хонхрын гарал үүслээс ихээхэн хамаардаг. Манай орны нууруудын ихэнх нь гарал үүслийн хувьд эртний мөсдөл, түүний дараах үе буюу Плейстоцен, Голоцены галчид хамрагдах боловч Хөвсгөл, Буйр болон Их нууруудын хотгор, Нууруудын хөндийн томоохон нуурууд нь геологийн эртний эринд үүссэн гэж үздэг. Нуурын хотгорыг гарал үүслээр нь дараах хэв шинжид хуваан үздэг (Цэрэнсодном, 2000). Үүнд:

- ✚ Тектоникийн гаралтай нуур
- ✚ Галт уулын гаралтай
- ✚ Мөстлөгийн гаралтай
- ✚ Усны эрозийн болон хуримтлалын гаралтай
- ✚ Нуралт-гулсалтын буюу

- ✚ Цөмрөлийн буюу суултын гаралтай
- ✚ Салхины гаралтай нуур гэсэн хэвшинжид ялгана.



Нуурын хотгорын гарал үүслийн төрлүүд

➤ **Тектоникийн гаралтай нуур**


Газрын давхаргын тектоник хөдөлгөөнтэй холбоотойгоор үүснэ. Тектоник хөдөлгөөний үр дүнд үүссэн уулс хоорондын том жижиг хотос, ховдол, ангал, зөрөгт хонхорт тогтсон нуур цөөнгүй байдаг (Цэрэнсодном, 2000). Тектоник гаралтай нуурууд насны хувьд өөр хоорондоо ялгаатай төдийгүй, гүн ихтэй байдаг. Манай орны Хөвсгөл, Увс, Хяргас, Үүрэг, Сангийн далай, Бөөн Цагаан, Орог, Буйр зэрэг олон нуурууд нь тектоник гаралтай болно.



Тектоникийн гаралтай а.Хөвсгөл, б.Увс, в.Хяргас нуурууд

➤ **Галт уулын гаралтай нуур**

Галт уулын үйл ажиллагаатай холбоотой үүссэн нуурыг хэлнэ. Галт уулын гаралтай нуурыг дотор нь галт уулын өрхөнд тогтсон, хүрмэн лаавын урсгалд хаагдаж тогтсон гэж хоёр төрөлд хуваадаг. Манай оронд геологийн янз бүрийн эрин галавуудад бялхаж, оргилж байгаад унтарсан 400 гаруй галт уул байдаг. Өрхөд тогтсон нуурууд хэмжээгээр бага, дугуй хэлбэртэй, голдуу хур борооны усаар тэжээгдэх тул зарим нь хатаж ширгэнэ. Галт уулын өрхөд үүссэн Хорго, Гичгэний бауруун, зүүн Тогоо, Өлийн тогоо, Уран тогоо, Шаврын царам, Босгын тогоо, Сугын тогоо, Залаа тогой, Тогоо хайрхан зэрэг нуурууд байна. Харин лаавын урсгалд хаагдаж үүссэн нуурууд Хануй, Хүнүй, Орхон, Чулуут, Гичгэнэ, Бийр, Сүүдэр, Битүүт, Улаан, Тэрх зэрэг голын хөндийд олноороо оршино.



Галт уулын өрхөнд тогтсон нуур


Тектоникийн ба галт уулын гаралтай нуурууд нь эндоген төрөлд хамаарагдана.



Галт уулын гаралтай Хорго болон Тэрхийн Цагаан нуур

➤ **Мөстлөгийн гаралтай нуур**

Мөстлөг, мөсөн голын үйл ажилгаатай холбоотой үүссэн нуур энэ бүлэгт орно. Манай орны өндөр уулт тогтолцоонууд төвийн өндөрлөг хэсгүүдээр эртний мөстлөгийн ор мөр хадгалагдан үлдсэн



байдаг. Тэгэхдээ уул нурууд өндрийн байдалтай уялдаад тус орны хамгийн өндөр Монгол Алтайн уулсад мөстлөгийн тархалт, зузаан, давтагдал бусдаас их байдаг бөгөөд харин эндээс зүүн тийш уул нуруудын өндөр намсахын зэрэгцээ мөстлөгийн тархалт, хэмжээ, давтагдлын тоо цөөн болсон. Үүнтэй уялдан мөстлөгийн гаралтай нуурууд ч энэ зүйд нийцэн тархжээ. Мөстлөгийн гаралтай нууруудын ихэнх нь мөстлөгийн төв хэсгээс зөөгдсөн уулын сэвсгэр хурдас болох моренд хаагдаж үүсдэг байна. Мөстлөгийн үйл ажиллагаагаар үүссэн

томоохон нууруудад Монгол Алтайн нуруунд Хотон, Хоргон, Толбо, Даян, Тал нууруу, харин Хангайн нуруунд Гурван булгийн Хөх, Отгонтэнгэрийн Хөх, Цагаан, Архангайн Хөх, Хөвсгөлийн уулст Дархадын хотгорын Доод Цагаан, Тарган зэрэг 200 гаруй бүлэг нуур, Хэнтий нуруунд Хагийн хар, Хөх, Хэрхлүүр Мөнгөн Хөл зэрэг нуурууд хамрагдана.



Мөстлөгийн гаралтай Толбо нуур ба Дархадын хотгорын бүлэг нуурууд

➤ **Усны эрозийн болон хуримтлалын гаралтай**

Тус орны гол мөрдийн усны горимтой уялдан хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед томоохон голуудын урсац эрс нэмэгдэн эргээ хальж хонхор газар усаар дүүрч нуур тогтоно. Мөн гол мөрөн голдирлоо солих, голдрилын идэгдлийн улмаас хар ус, цээл, тохой үүсэх, үерийн усанд голын эрэг эвдрэх зэргээс болж үүссэн нуурууд орно.


Ийм нуурууд манай орны томоохон голын хөндийд түгээмэл бөгөөд үүнд Архангай Өгий, Их нуур, Хөвсгөлийн Эрхэс, Шишхэд голын савын олон нуурууд, Булганы Айрхан, Чингийн Цагаан, Улз голын сав дагуух Дээд, Доод Дөрөө, Тээлийн Цагаан, Их, Бага Далай зэрэг нуурууд багтана. Харин голууд үгүй болсноос үүссэн нууруудад Дорнодын тал, Матад-Тамсагийн хоорондох том ховдол, Лагийн хоолой зэрэг эртний голын хөндийд нилээд тархжээ. Томхон гол мөрдийн садраа адаг тогтсон Ховд голын адаг, Завхан голын адаг, Халх, Оршуун, Улз голын адгаар байх бүлэг нуурууд энэ хэв шинжийн гаралтай нуурт хамрагдана.



Урсгал усны гаралтай Өгий нуур

➤ **Нуралт-Гулсалтын гаралтай нуур**


Дэлхийн гадаад хүчний үйл нэгэн үйл явц болох хүндийн хүчний нөлөөгөөр манай орны уулархаг нутагт хад асга нуран шилжих, уулын хажуугийн хурдас гулсаж гол горхины хөндийг боож хааснаас нуур тогтоно. Энэ хэв шинжийн Монгол Алтай, Хөвсгөл, Хэнтий нурууны оройн хэсэгт тархах бөгөөд үүнийг Тагийн нуур ч гэж нэрлэнэ. Түүнчлэн хөрсөн бүрхэвч хүндийн хүчний нөлөөгөөр уулын хажууг даган шилжиж гулсаж мөн нуур үүснэ.



➤ **Цөмрөлийн буюу суултын гаралтай**

Энэ хэв шинжийн нуурууд үүсэх үндсэн нөхцөл нь олон жилийн цэвдэг, тухай нутаг орны хурдас чулуулгийн төрөл, түүний шинж чанартай холбоотой. Тус орны нутаг дэвсгэрт тархсан олон жилийн цэвдэг нь дөрөвдөгч галавын мөстлөгтэй холбоотой бөгөөд нутгийн хойд хэсгээр өргөн уудам нутгийг эзэлнэ. Цэвдгийн үзэгдлүүд дотроос ялангуяа термокарстын үзэгдэл нь нуур үүсэхэд шууд нөлөөлнө.

Олон жилийн цэвдэг тархсан газарт цэвдэгт хөрсний дулааны горим ямар нэгэн хүчин зүйлсийн үйлдлээр алдагдаж цэвдэг гэсэж үүссэн хотгор нь нуур тогтдог ийм цэвдгийн гаралтай нуурууд талбайн хувьд бага, эрэг нь



налуу, дугуйдуу хэлбэртэй, төдийлөн гүн биш урсгалтай, урсгалгүй байна. Цэвдгийн гаралтай нууруудад Хангай нурууны Тэс, Чулуут, Өлзийт, Завхан голын эх, Шишхэд голын хөндийд орших бүлэг нуурууд багтана. Харин тухайн нутаг оронд тархсан шохойн чулуу, гөлтгөнө үүлэн цагаан зэрэг чулуулгууд усанд хялбар уусдаг учир тэнд хөндийлжийн (суффози) гаралтай нуур үүсдэг. Ийм

цөмрөлийн гаралтай нуурууд гэвэл тус улсын зүүн хойт захын Улз голын сав нутаг дахь Шаварт, Бүс, Монгол Цагаан, Сүм, Үхэрт, Тэсийн голын хөндийд Асгат, Элээт, Шишхэдийн хотгорын Шарга, Арсай, Хотон голын сав дахь бүлэг нуурууд орно (Санжмятав, 2009).



Термокарстын нуур

➤ **Салхины гаралтай нуур**

Манай орон хуурай, хур чийгээр дутмаг учир салхины үйл ажиллагаа бүсийн шинж чанартай явагдана. Үүнтэй уялдан салхины үлээж элэгдүүлэх, хуримтлуулах үйл ажиллагаанаас үүдэн салхин гарлын нуурууд үүснэ. Тус орны элсэн тарамцгуудын ихэнх нь Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд ноогдохоос гадна Дорнод хэсгийн талархаг газар, Алтайн цаад говь, зүүн өмнөд хэсэгт Молцог элс оршино. Салхины үйл ажиллагаагаар элс зөөвөрлөгдөж голын хөндийг боосноос үүссэн нуурууд Завхан, Хүнгүй, Тэс, Нарийн голын хөндий дэх Хунт, Бага, Увсын Баян, Дөрөө, Говь-Алтайн Сангийн далай, Эрээн нуурууд орно. Харин салхин гарлын хонхорт тогтсон нууруудад Хэнтийн Гүрэм, Халх, Нөмрөг, Мухарын голын сав Онгон, Молцог элсний орчмын олон жижиг нуурууд, говь цөлийн ландшафтын нөхцөлд орших боловч ус нь шүүрэлтийн үйл ажиллагаагаар цэнгэг байдаг (Санжмятав, 2007).



Салхины гаралтай а.Эрээн, б.Дөрөө, в.Гүрэм нуурууд

Ашигласан материал

1. Е.Батчулуун (2003). Дэлхий судлал. “Мөнхийн Үсэг” ХХК, Улаанбаатар.
2. Ж. Цэрэнсодном (2000). Монгол орны нуурын каталог. Улаанбаатар.
3. З.Санжмятав (2007). Монгол орны байгалийн газарзүй. Улаанбаатар.